



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: АРА-2024/11/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитор А.Пүрэвцэцэг Утас: 99746363 Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	1
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Компаний гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт ...	Error! Bookmark not defined.
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	Error! Bookmark not defined.
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Төлбөрийн акт	9
5.2 Албан шаардлага	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.15 № 150
танай _____-ны № _____-т

“АРХАНГАЙД ҮЙЛДВЭРЛЭВ”
ОНӨҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАЯРЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Архангайд үйлдвэрлэв” ОНӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөг эс тооцвол “Архангайд үйлдвэрлэв” ОНӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчлүүд тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь дангаараа болон нийт дүнгээрээ материаллаг байдлаас давсан тул хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлант онд батлагдсан зардлыг 13543.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн, 66,720.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь Төрийн болон өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн “2. Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” заалтыг зөрчиж байна.
2. Худалдан авалтын 6,323,456 төгрөгийн цахим төлбөрийн баримтгүй, 1,646,630 төгрөгийн худалдан авалтыг нотлох анхан шатны баримтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дахь хэсэгт заасныг зөрчсөн бөгөөд аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
3. Нийт 2093144 төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг зөрчсөн, аудитын

4. Тайлангийн жилд 5,084,990 төгрөгийн авлага, 6,170,336.57 төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.5 дахь хэсэгт заасныг зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
5. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг огт байршуулаагүй Шилэн дансны тухай хуулийн 5.1, 5.5, 3.2-т дахь хэсэгт заасныг зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны Б/58 дугаар захирамжаар байгууллагын захирлыг шинээр томилсон байна.

Аудитын гол асуудал

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ нь 2023 оны Бизнес төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар 2023 оны 02 дугаар сарын 20-нд батлуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 онд Зорилтот түвшин эдийн засгийн үзүүлэлтээр 205,176.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлан 241,288.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын гүйцэтгэл 17.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	56,565,501.68	43,626,893.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	46,847,256.68	35,124,640.76
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	46,847,256.68	35,124,640.76
31210	Төгрөг	46,847,256.68	35,124,640.76
31213	Арилжааны банк дахь харилцах	46,847,256.68	35,124,640.76
33	АВЛАГА	5,541,245.00	5,085,253.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	4,396,750.00	3,643,800.00
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	1,144,495.00	1,441,453.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,177,000.00	3,417,000.00
35400	Хангамжийн материал	4,177,000.00	3,417,000.00
35420	Аж ахуйн материал	2,380,000.00	680,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,797,000.00	2,737,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,832,503,034.26	2,782,228,501.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,832,503,034.26	2,782,228,501.52
39200	Биет хөрөнгө	2,819,950,367.59	2,770,278,501.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,899,489,084.00	2,899,489,084.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-143,003,850.99	-191,328,669.06
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,218,900.00	6,218,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,572,575.00	-3,479,475.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,162,100.02	14,862,100.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,920,770.00	-4,176,090.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	63,672,530.00	71,490,530.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-15,095,050.44	-22,797,878.44
39300	Биет бус хөрөнгө	12,552,666.67	11,950,000.00
39301	Програм хангамж	904,000.00	904,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-301,333.33	-904,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,950,000.00	11,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,889,068,535.94	2,825,855,395.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,467,450.79	35,332,206.59
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,467,450.79	35,332,206.59
41300	Өглөг	3,758,740.79	6,170,336.59
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	34,383.87	736,064.92

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

41360	Бусад өглөг	3,724,356.92	5,434,271.67
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	3,724,356.92	5,434,271.67
41400	Урьдчилж орсон орлого	28,708,710.00	29,161,870.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	28,708,710.00	29,161,870.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,856,601,085.15	2,790,523,188.69
51	Засгийн газрын хувь оролцоо	2,856,601,085.15	2,790,523,188.69
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,154,084,200.00	3,154,084,200.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-297,483,114.85	-363,561,011.31
51210	Өмнөх үеийн үр дүн	-24,717,451.67	-296,840,077.17
51220	Тайлант үеийн үр дүн	-272,765,663.18	-66,720,934.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,889,068,535.94	2,825,855,395.28

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа /төгрөгөөр/
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	203,782,846.73	218,449,300.91
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3. Нийт ашиг (алдагдал)	203,782,846.73	218,449,300.91
10. Ерөнхий ба удирдлагын зардал	230,418,787.57	285,000,935.05
12. Бусад зардал	201,682.00	169,300.00
13. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	245,928,040.33	
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-272,765,663.18	-66,720,934.14
19. Орлогын татварын зардал		
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-272,765,663.18	-66,720,934.14

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн /төгрөгөөр/
1	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	-	-	-297,483,114.85	2,856,601,085.15
3	Залруулсан үлдэгдэл	-	-		
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-66,720,934.14	-66,720,934.14
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-		
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-		
7	НББ-н бодлогын өөрчлөлт	-	-	643,037.68	643,037.68

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн	-	-		
9	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-	-363,561,011.31	2,790,523,188.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа /төгрөгөөр/
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	217,705,912	237,967,266.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	192,521,735.00	213,255,455.00
Бусад мөнгөн орлого	25,184,177.00	24,711,811.00
1.2 Мөнгөн зарлагын дүн	191,413,624.01	244,492,881.92
Ажиллагчдад төлсөн	66,609,426.00	87,472,780.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	18,673,347.17	23,950,173.41
Бараа материал худалдан авахад төлсөн	15,675,170.00	22,220,959.00
Ашиглалтын зардал төлсөн	48,049,069.58	63,698,632.25
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	37,216,708.26	33,121,886.26
Бусад мөнгөн зарлага	5,189,903.00	14,028,451.00
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	26,292,287.99	-6,525,615.92
2. Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ		
2.1 Мөнгөн орлогын дүн	9,058,360.00	3,321,000.00
2.2 Мөнгөн зарлагын дүн	7,661,200.00	8,518,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,661,200.00	8,518,000.00
2.3 Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	1,397,160.00	-5,197,000.00
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1 Мөнгөн орлогын дүн		
3.2 Мөнгөн зарлагын дүн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	27,689,447.99	-11,722,615.92
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,157,708.69	46,847,256.68
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,847,156.68	35,124,640.76

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

ДД	Зардлын зүйл анги	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь /төгрөгөөр/
1	Цалин	92,359,632.00	104,799,999.00	12,440,367.00	13.47
2	НДШ	11,544,954.00	12,451,345.23	906,391.23	7.85
3	Бичиг хэрэг	2,907,234.00	690,080.00	-2,217,154.00	-76.26
4	Тээвэр шатахуун	0	2,228,949.23	2,228,949.23	100.00
5	Гэрэл цахилгаан	35,283,840.00	47,868,708.94	12,584,868.94	35.67
6	Түлш халаалт	8,972,197.00	5,000,000.00	-3,972,197.00	-44.27
7	Цэвэр бохир ус	9,109,200.00	8,396,311.00	-712,889.00	-7.83

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

8	Хангамж бараа материалын зардал	8,181,520.00	8,181,520.00	0.00	0.00
	Бусад зардал	10,895,850.00	10640702.11	-255,147.89	-2.34
10	Үндсэн хөрөнгө олж эзэмших	8,255,000.00	8,518,000.00	263,000.00	3.19
11	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	17,396,940.00	17,432,786.80	35,846.80	0.21
11	Зардлын нийт дүн	204,906,367.00	226,208,402.31	21,302,035.31	10.40

1. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,300.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- ✓ Татварын 1,441.3 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй
- ✓ Татварын 798.4 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй,
- ✓ НДШ өглөг 61.2 мянган төлбөрийг санхүүгийн тайланд буруу бүртгэснийг залруулав.

Залруулагдаагүй 20,390.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 2,093.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 7,041.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 11,255.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж, шилэн дансны тайлагналтай холбоотой 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд анхан шатны баримтгүй 441.6 мянга, батлагдсан нормоос хэтрүүлэн 1,651.4 мянга, нийт 2093.0 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан байна.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалаар батлагдсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" нэгдүгээр хавсралттай мөн нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй болон батлагдсан нормоос хэтрүүлэн ашигласан шатахууны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлэв.

5.2 Албан шаардлага

5.2.1 Зардлын гүйлгээг нярвын тайлан руу тулган шалгахад 6,323.4 мянган төгрөгийн худалдан авалтыг нотлох цахим төлбөрийн е-баримтгүй, 1,646.6 мянган төгрөгийн худалдан авалтыг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 Тайлант онд 218,449.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн 285,170.2 мянган төгрөгийн зардал гаргаж 66,720.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид үйл ажиллагааны зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг боловсруулан ашигт ажиллагааг нэмэгдүүлэх албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

5.3.1 Өр төлбөртэй холбоотой асуудал

Түрээсийн авлага 3,643.9 *мянган* төгрөг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 1,144.4 *мянган* төгрөг, Суутгагчийн хуулийн этгээдэд олгосон орлогоос суутгасан татвараас 296.5 *мянган* төгрөг нийт 5,084.9 *мянган* төгрөгийн авлага, Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын 1,715.8 *мянган* төгрөг, Дотоодын бараа, үйлчилгээний суутгасан НӨАТ-ын 3,718.4 *мянган* төгрөг, цалингийн өглөг 736.0 *мянган* төгрөг нийт 6,170.3 *мянган* төгрөгийн өглөгийн тооцоотой байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Богино хугацаат өр төлбөр, *авлагыг* бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

5.3.2 Дотоод хяналт

Тус газар нь дотоод хяналтын нэгж байгуулаагүй, тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ”, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна”гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: *Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах*

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дугаарын 21-ны дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөрийг барагдуулаагүй	1	11,255.3					1	11,255.3				
Шатахуун анхан шатны баримтгүй, батлагдсан нормын дагуу зарцуулаагүй	1	2,093.1	1	2,093.1								
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	7,041.8			1	7,041.8						
Дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1						1					
Алдагдалтай ажилласан	1				1							
Дүн	5	20,390.3	1	2,093.1	2	7,041.8	2	11,255.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Мэдээлэл байршуулаагүй	1	0.0						1	0.0
Дүн	1	0.0						1	0.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.